

2024 ОНЫ 08 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 09 дүгээр сарын 04-ний “Лхагва” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ-ийн мэргэжилтэн (ERP Б.Одбаяр)-д файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

| № | Өгсөн үүрэг даалгавар | Хариуцах эзэн |
|--|--|---|
| НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР | | |
| 1 | Нийслэлийн 2024 оны төсвийн өөрчлөлтийн тодотголын бэлтгэл ажлыг хангахтай холбогдуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. | СТСХ, Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ |
| 2 | Жолооч нарыг авто замын хөдөлгөөнд соёлтой оролцуулах, замын хөдөлгөөний дүрэм, журмыг зөрчиж татвар, торгуулиа төлөөгүй болон тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоонд ороогүй тээврийн хэрэгслийг хөдөлгөөн оролцуулахгүй байх. | Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг, Татварын хэлтэс |
| 3 | Барилгын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлж, олон нийтэд тогтмол мэдээлэх, барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчны аюулгүй байдалд хяналт тавьж ажиллах. | Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, холбогдох байгууллагууд |
| 4 | Хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан хоол, хүнсний, бараа бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, стандартыг мөрдүүлж, аюулгүй байдлыг хангуулан хяналт шалгалтыг эрчимжүүлж ажиллах. | Боловсролын хэлтэс, ТХҮХ, Ажлын хэсэг |
| 5 | Ерөнхий боловсролын сургуулийн орчинд сурагчид гэмт хэрэг, хэв журмын зөрчил болон зам, тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган камержуулах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. | НХХ, Цагдаагийн хэлтэс, Боловсролын хэлтэс |
| 6 | Дүүргүүд өөрсдийн нөөц, төсвийн зохицуулалтын хүрээнд борооны улмаас эвдэрч гэмтсэн автозам, гудамж, талбай, ногоон байгууламжуудаа нөхөн сэргээх ажлуудаа эрчимжүүлэх хүрээнд тооцоо судалгаа хийж танилцуулах. | Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ |
| 7 | Хот нийтийн аж ахуйн чиг үүргийн хүрээнд шинээр худалдан авах, нэн шаардлагатай тусгай зориулалтын машин, механизмуудын судалгааг гаргаж, төсвийн тодотголд тусгуулах талаар бэлтгэл ажлыг хангах. | Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ |
| 8 | Ногоон байгууламжууд дахь зүлэг, шарилж, мод, бутыг засаж жигдлэх ажлуудаа эрчимжүүлж дуусгах. | Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ |
| 9 | Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд давс, бодисын нөөц бүрдүүлж, цас хайлуулах давс, бодис худалдан авах эрхийг дүүргүүдэд шилжүүлж, худалдан авах ажиллагааг яаралтай зохион байгуулах. | Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ |
| 10 | Дүүргийн хэмжээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг бүрэн барагдуулж, хуулийн хугацаанд нь иргэнд хариу өгч ажиллах. | ТЗУХ, Нийт байгууллагууд |
| 11 | Дүүргийн хэмжээнд хөрсний ус зайлуулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр санал боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах. | Дүүргийн менежер Г.Дагвадорж, ТХҮХ |

| | | |
|---|---|--|
| 12 | Хяналт шалгалтын чиглэлээр тодорхой санал боловсруулж танилцуулах. | ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, ТХҮХ |
| 13 | Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхэд, багачууд, сурагч нарт зориулсан “Хот” гэдэг иж бүрэн хөтөлбөр боловсруулж, зохион байгуулахтай холбогдуулан холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх. | НХХ, Холбогдох байгууллагууд |
| 14 | Төр хувийн хэвшлийн түншлэлийн чиглэлээр нутгийн захиргааны байгууллагуудад сургалт зохион байгуулахтай холбогдуулан дүүргийн зүгээс холбогдох саналыг нэгтгэхэд бэлтгэх. | ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, Нийт байгууллагууд |
| ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР | | |
| 15 | Хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг эрчимжүүлэх. | Ажлын хэсэг, Ашиглагч байгууллагууд |
| 16 | 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч дүүрэгт ажиллах түл бэлтгэл, бэлэн байдлыг сайтар хангах. | Нийт байгууллагууд |
| 17 | 2024 оны 09 дүгээр сарын эхний 7 хоногт дүүргийн Засаг даргын Зөвлөлийн хурал хуралдахтай холбогдуулан холбогдох бэлтгэлийг ханган ажиллах. | ЗДТГ, ААНБ-ууд |
| 18 | Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар гарган иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд танилцуулахад бэлтгэх. | ЗДТГ, ААНБ-ууд |
| 19 | Дүүргийн ААНБ-ууд тус бүр 2023-2024 онд хийгдсэн ажлуудын мэдээллээ нэгтгэн богино хэмжээний видео хэлбэрээр иргэд, олон нийтэд мэдээлэх. | Нийт байгууллагууд |
| 20 | Мэдээлэл шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг эрчимжүүлэх. | ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, Ажлын хэсэг |
| 21 | Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай дахь явган замыг нөхөн сэргээх ажлыг гүйцэтгэх. | Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Гүйцэтгэгч ХХК |

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР